**МОНГОЛ УЛС**
**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 11 өдөр Дугаар А/549 Есөнбулаг

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэхь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 39 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 35.000.000 (гучин таван сая) төгрөгийн санхүүжилтээр Ерөнхийлөгчийн санаачилсан тэрбум мод үндэсний хөдөлгөөн, аймгийн "108 сая мод" арга хэмжээний хүрээнд Цогт сумын Төгрөг багт заг тарих ажлын эрхийг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Д.Батмагнай)-т шилжүүлсүгэй.

2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, журмын дагуу 11 дүгээр сарын 01-ны өдрийн дотор зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Д.Батмагнай)-т үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Г.ЧИНБАТ

C:Documents/ ZD A-4 doc

8200011180

8200711746